

## НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2015 ОНЫ

### ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

#### НЭГ. БҮТЭЦ, ОРОН ТОО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх дотоод аудитын нэгжтэй байна.” гэж заасны дагуу Нийслэлийн Засаг даргын 2014 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/156 дугаар захирамжаар “Нийслэлийн Дотоод аудитын алба”-ыг Санхүүгийн аудитын хэлтэс, Гүйцэтгэлийн аудитын хэлтэс, Чанарын хяналтын хэлтэс, Захиргаа, хуулийн хэлтэс гэсэн 4 хэлтэс, 3 ахлах аудитор, 1 ахлах шинжээч, 4 аудитор, 8 шинжээч, 1 нягтлан бодогчтой нийт 22 албан хаагчтайгаар ажилласан.

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтанд хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгөх, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр нийслэлийн төсөвт байгууллага, нийслэлийн өмчит, нийслэлийн өмч давамгайлсан үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын дэргэдэх хараат бус хэрэгжүүлэгч агентлаг юм.

Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын эрсдэлийн удирдлага, засаглал, дотоод хяналтын үйл явцыг хараат бус, бие даасан байдлаар үнэлэн дүгнэлт, зөвлөмж өгч, үйл ажиллагааг сайжруулахад манай эрхэм зорилго оршино.

Эрхэм зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг тодорхойлон байгууллагын жилийн болон дунд хугацааны төлөвлөгөөнд тусган Дотоод аудитын хорооны даргаар батлуулан ажилласан. Үүнд:

1. Аудитын дунд хугацаанд аудитын хамрах хүрээний бүх объектуудад эрсдэлд суурилсан дотоод аудитыг хийн, дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх;
2. Судалгаа шинжилгээ хийн, сургалт явуулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын засаглал, эрсдлийн удирдлагын тогтолцооны үр ашгийг дээшлүүлэх зорилгоор арга зүйн зөвлөмжөөр хангах;
3. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийг үнэн зөв мэдээллээр ханган, удирдлагын тогтолцоог төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулах.

Дээрх зорилтуудыг хангах ажлын хүрээнд Захиргаа, хуулийн хэлтэс нь байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа болох нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгөх ажлыг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх, удирдлагын шийдвэр гаргах үйл явцыг

шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, байгууллагын хүний нөөцийн бодлогыг зөв хэрэгжүүлэх, ажилтан албан хаагчдын нийгмийн асуудлыг шуурхай шийдвэрлэх ажлыг хэлтсийн дарга Я.Сарансүх, ахлах нягтлан бодогч Б.Сэргэлэн, мэдээллийн технологи хариуцсан шинжээч С.Болор-Эрдэнэ, дотоод ажил хариуцсан шинжээч /архив, бичиг хэрэг хавсран гүйцэтгэгч/-ээр Б.Солонгожаргал нарын бүрэлдэхүүнтэйгээр эрхлэн гүйцэтгэсэн.

Байгууллагын дүрмээр хүлээсэн үүрэг, зорилго, зорилтыг хангахын тулд Захиргаа, хуулийн хэлтэс чиг үүргийнхээ хүрээнд дараах ажлуудыг 2015 онд хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч Дотоод аудитын албаны даргатай байгуулсан 2014 оны үр дүнгийн гэрээний биелэлтийг 2015 оны 1-р сард Нийслэлийн Засаг даргын тамгын газрын ажлын хэсэгт амжилттай тайлагнаж, “хангалттай” үнэлгээ авсан. Дотоод аудитын албаны даргын 2015 оны үр дүнгийн гэрээг 2015.02.16-нд байгуулснаар байгууллагын 2015 оны үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөөг, Нийслэлийн Дотоод аудитын хорооны 2015.01.21-ний өдрийн хурлаар байгууллагын 2014 оны аудитын тайланг хэлэлцүүлж, 2015 оны аудитын төлөвлөгөөг тус тус батлуулсан.

Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг улирал, хагас, бүтэн жилээр нэгтгэн гаргаж, нийслэлийн Дотоод аудитын хорооны 2 удаагийн хурлаар 2014 оны аудитын тайлан, 2015 оны эхний 5 сарын аудитын тайланг танилцуулсан.

2015.02.24-нд байгууллагын дарга 4 нэгжийн даргатай, нэгжийн дарга нар нийт албан хаагчтай 2015 оны үр дүнгийн гэрээ байгуулснаар хэлтэс, албан хаагчдын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. 2015 оны жилийн эцсийн байдлаар нийт 21 албан хаагчтай үр дүнгийн гэрээ, 1 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангуулан, үр дүнг хагас, бүтэн жилээр тооцон, зохих урамшуулалыг олгосон.

Байгууллагын даргын зөвлөлийн хурал, байгууллагын шуурхай зөвлөгөөнийг 14 хоног тутам, хэлтсийн хурлыг 7 хоног тутам зохион байгуулж, хэлтсүүд ажлаа 7 хоногоор төлөвлөж, өгсөн үүрэг даалгаварын биелэлтэд хяналт тавьж, даргын зөвлөлийн хуралд танилцуулан ажилласан.

Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уядуулан авлигын эсрэг, сургалтын, биеийн тамир, спортын хамтлагийн, э-оффис програм нэвтрүүлэх, архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын шалгалтад бэлтгэх зэрэг дэд төлөвлөгөөнүүдийг боловсруулан батлуулж ажилласан. Биелэлтийг хагас, бүтэн жилээр болон тухайн хугацаанд нь гаргаж байгууллагын даргад болон даргын зөвлөлд тайлагнасан.

2. Байгууллагын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх чиглэлээр:

Захиргаа, хуулийн хэлтсийн дарга, ахлах аудитор, ахлах шинжээч нарын 3 ажлын байрны тодорхойлолтыг шинээр боловсруулж, аудитор, шинжээч, ахлах нягтлан бодогч, дотоод ажил хариуцсан шинжээч, мэдээллийн технологи хариуцсан шинжээч нарын 5 ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, мөрдөн ажилласан.

Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг Төрийн албаны зөвлөлийн програмд шинээр мэдээллийн бааз үүсгэн оруулсан бөгөөд нийслэл дэх төрийн албаны салбар зөвлөл, нийслэлийн Засаг даргын тамгын газрын Нутгийн захиргааны удирдлагын хэлтэст хүний нөөцтэй холбоотой шаардлагатай мэдээ, судалгааг цаг тухай бүрт нь гаргаж өгснөөс гадна 4 албан хаагч шинээр төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөсөн.

Албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх дунд хугацааны “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”, “Хүний нөөцийн сургалтын хөтөлбөр”, 2015 оны сургалтын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлж ажилласан. 2015 онд давхардсан тоогоор нийт 126 албан хаагчийг мэргэжлийн ур чадварыг нь нэмэгдүүлэх төрөл бүрийн сургалтад хамруулж, үүнтэй холбоотойгоор 5,935.0 төгрөгийн зардал гаргасан. Үүнд:

- Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох АЗ сургалтын шалгалтад Д.Үүрийнтуяа, С.Буманцэцэг, Н.Наранчимэг, Б.Уранбилэг, П.Батбилэг, Д.Лувсанчимэд, Г.Шүрэнцэцэг, Б.Сэргэлэн, Б.Мягмарзаяа, Ц.Болдбаатар нарын 10 аудитор, шинжээч тэнцэж гэрчилгээ авсан.
- Нийслэл 9 дүүргийн 32 аудитор, шинжээчид оролцсон Интерактив ХХК, НМТГ-аас зохион байгуулсан нийслэлийн Шилэн дансны системийн сургалтад холбогдох албан хаагчид хамрагдсан.
- Аудитор Б.Уранбилэг нь Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас зохион байгуулсан нийслэл, дүүрэг, хороодын нутгийн захиргааны байгууллагын биеийн тамир спортын хамтлагийн "Эрүүл орчин-Эрүүл амьдралын хэв маяг" сэдэвт сургалтад 4 сарын 2,3-ны өдрүүдэд хамрагдсан.
- Дэлхийн банк, Сангийн яамнаас зохион байгуулсан Дотоод аудитын сургалтад дарга Д.Нацагдорж, Санхүүгийн аудитын хэлтсийн дарга Д.Үүрийнтуяа, Гүйцэтгэлийн аудитын хэлтсийн шинжээч Н.Наранчимэг нар оролцсон.
- Нийслэлийн Архивын газрын зөвлөмжийн дагуу нийт ажилтан, албан хаагчдад "Баримт бичиг боловсруулалтын үйл ажиллагаанд стандартыг оновчтой мөрдөх нь", "Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт" зэрэг 4 удаагийн болон Монгол хэлний зөвлөлөөс журамласан 700 үг"-ийн сургалт явуулснаар гадна Дотоод ажил хариуцсан шинжээч Б.Солонгожаргалыг байгууллагын зардлаар архивчийн мэргэжлийн гэрчилгээтэй сургалтад хамруулсан.
- 7 албан хаагчийг мэргэжлийн англи хэлний сургалтад хамруулсан.
- Сангийн Яам Төсвийн хяналт эрсдлийн удирдлагын газрын Дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэстэй хамтран зохион байгуулсан "Дотоод аудитын ажлын баримтыг хэрхэн сайн хөтлөх вэ сургалт"-д нийт албан хаагчид бүрэн хамрагдсан;
- Хүний нөөц, э-оффис, өргөдөл, гомдлын нэгдсэн систем smartcity.mn програм, "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам"-ын сургалтад холбогдох албан хаагчид хамрагдсан.
- Аудитор Д.Лувсанчимэд мэргэшсэн нягтлан бодогчийн 5 жилийн эрх сунгах сургалтанд хамрагдаж шалгалт өгч тэнцсэн.
- Аудитор Д.Лувсанчимэд Удирдлагын академийн 2015-2016 оны хичээлийн элсэлтийн шалгалтанд тэнцэж суралцах болзлыг хангасан.
- Шинжээч Б.Отгонцэрэн Мэргэшсэн нягтлан бодогчийн сорил шалгалт "Мэдээлэл, технологи-ур чадвар, Ёс зүй, мэргэжлийн үнэ цэнэ, Цогц бодлого" шалгалтад тэнцэж батламж авсан.
- 2015.10.22-нд Азийн хөгжлийн банкнаас зохион байгуулсан авлигын эсрэг семинарт ЗХХ-н дарга Я.Сарансүх оролцож гэрчилгээ авсан.

- Энэтхэгийн ЗГ-ын эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны “Нийгмийн хөгжлийн сургалтын хөтөлбөр”-т хамрагдахыг хүссэн, болзол шаардлагыг хангасан 8 албан хаагчийн материалыг хүргүүлсэн.
- Гадаад оронд болох сургалт, семинарт оролцох хүсэлтээ Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газар, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Гадаад харилцааны хэлтэс, Төсөл, хамтын ажиллагааны хэлтэст удаа дараа тавьсан. СЯ-ны Дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс санал болгосон Словен улсын Center of Excellence in Finance байгууллагын сургалтад аудитор, шинжээчдээ ирэх онд хамруулахаар судалж байна.
- “ИБУИНВУ-ын улсын секторын дотоод аудитын стандарт”, “Малайзын улсын секторын дотоод аудитын үр ашигтай байдал” гэсэн бичиг баримтуудыг цахим хуудаснаас татан авч танилцан, өөрийн үйл ажиллагаанд нэвтрүүлж болох туршлагыг судалж байна.
- Байгууллагын дарга Д.Нацагдорж, Гүйцэтгэлийн аудитын хэлтсийн ахлах аудитор Б.Эрдэнэсүрэн нар АНУ дахь Дотоод аудитын институтын гишүүнээр элссэн.

3. Албан хаагчдыг ажиллах нөхцөл бололцоогоор хангах, ажлын үр дүнг үнэлэх, ажлын идэвх санаачлагыг нэмэгдүүлэх чиглэлээр:

- Албан хаагчдын үр дүнгийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, нийт 29,332.7 мян.төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгон, 8 албан хаагчийн албан тушаалын зэрэглэлийг ахиулсан.
- Албан хаагчдын мэргэжлээрээ ажилласан жил, ажлын туршлага, амжилтыг нь харгалзан, болзол шаардлагыг хангасан албан хаагчдыг зохих шагналд тодорхойлсноор Хөдөлмөрийн хүндэт медалиар Санхүүгийн аудитын хэлтсийн дарга Д.Үүрийнтуяа, Чанарын хяналтын хэлтсийн дарга С.Буманцэцэг, Захиргаа, хуулийн хэлтсийн дарга Я.Сарансүх, Санхүүгийн аудитын хэлтсийн аудитор Б.Уранбилэг, Гүйцэтгэлийн аудитын хэлтсийн шинжээч Н.Наранчимэг нар Сангийн яамны “Жуух бичиг”-ээр, Нийслэлийн 376 жилийн ойг тохиолдуулан Гүйцэтгэлийн аудитын хэлтсийн дарга Ж.Жамбалдорж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт тэмдэг”-ээр, Захиргаа, хуулийн хэлтсийн дарга Я.Сарансүх Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт үнэмлэх”-ээр, Санхүүгийн аудитын хэлтсийн дарга Д.Үүрийнтуяа нийслэлийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр, жилийн эцсийн ажлын үр дүнгээр Санхүүгийн аудитын хэлтсийн шинжээч Б.Отгонцэрэн, ахлах нягтлан бодогч Б.Сэргэлэн нар нийслэлийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр, Захиргаа, хуулийн хэлтсийн мэдээллийн технологи хариуцсан шинжээч С.Болор-Эрдэнэ Монголын Залуучуудын Холбооны “Тэргүүний залуу” алтан медаль, Гүйцэтгэлийн аудитын хэлтсийн шинжээч Ц.Болдбаатар, Захиргаа, хуулийн хэлтсийн шинжээч Б.Солонгожаргал нар нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын “Шилдэг залуу” медалиар тус тус шагнуулж, “Оны шилдэг ажилтан”-аар Санхүүгийн аудитын хэлтсийн ахлах аудитор Д.Лувсанчимэд, Санхүүгийн аудитын хэлтсийн аудитор Б.Уранбилэг, Захиргаа, хуулийн хэлтсийн дарга Я.Сарансүх нар, “Оны шилдэгийн шилдэг ажилтан”-аар Гүйцэтгэлийн аудитын хэлтсийн ахлах шинжээч Н.Наранчимэг шалгарч мөнгөн шагналаар шагнуулсан.
- Албан хаагчдын нийгмийн баталгааны суурь судалгааг хийснээр тэдний нийгмийн баталгааг хангах талаар анхааран ажиллалаа. Тухайлбал Гүйцэтгэлийн аудитын хэлтсийн дарга Ж.Жамбалдорж, шинжээч Н.Наранчимэг

нарын хүүхэд гадаадад эмчлүүлсэн, Захиргаа, хуулийн хэлтсийн шинжээч Б.Солонгожаргал яаралтай хагалгаанд орж эмчлүүлсэн, Санхүүгийн аудитын хэлтсийн шинжээч Ц.Болдбаатар, Б.Ононбайгаль нар шинэ хүүхэдтэй болсон, Гүйцэтгэлийн аудитын хэлтсийн шинжээч Н.Наранчимэг, Санхүүгийн аудитын хэлтсийн шинжээч Б.Ононбайгаль, Гүйцэтгэлийн аудитын хэлтсийн шинжээч Ц.Болдбаатар, Санхүүгийн аудитын хэлтсийн ахлах аудитор Д.Лувсанчимэд нар шинэ байранд орсон, Санхүүгийн аудитын хэлтсийн дарга Д.Үүрийнтуяагийн төрсөн эцэг нас барсан, Чанарын хяналтын хэлтсийн аудитор П.Батбилэг өөрийн төрсөн нутаг руу явж ирсэн, түлээ, нүүрсний хөнгөлөлтийг Санхүүгийн аудитын хэлтсийн шинжээч Б.Отгонцэрэн, Захиргаа, хуулийн хэлтсийн дотоод ажил хариуцсан шинжээч Б.Солонгожаргал нарт байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу 2015 онд нийт 7,792.3 мянган төгрөгийн нэг удаагийн дэмжлэг, тусламж олгосон. Байгууллагын албан хаагчдын насанд хүрээгүй 24 хүүхдэд хүүхдийн баяраар 840,000 төгрөгийн, шинэ жилийн баяраар гэр бүлд нь 665,160 төгрөгийн бэлэг өгсөн. Гэр хороололд амьдардаг, нийслэлийн байгууллагад олон жил ажилласан Санхүүгийн аудитын хэлтсийн ахлах аудитор Д.Лувсанчимэд, Захиргаа, хуулийн хэлтсийн дотоод ажил хариуцсан шинжээч Б.Солонгожаргал нарт “Улаанбаатар орон сууц сан”-аас манай байгууллагад олгосон квотын дагуу орон сууцны урьдчилгаа төлбөрийн 22,880.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

- Албан хаагчдын бие бялдарыг чийрэгжүүлэх зорилгоор Усан спорт, сургалтын төвд хөнгөлттэй үнээр 6 албан хаагч суралцсан. Байгууллагын 1 жилийн ойд зориулан боулингийн тэмцээн зохион байгуулсан. Мөн Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газар, Нийслэл, дүүргийн Дотоод аудитын албадын дунд “Дотоод аудит-2015” анхдугаар спорт тэмцээнд амжилттай оролцож, манай гар бөмбөгийн холимог баг 1-р байр эзэлсэн. Мөн албан хаагчдын төрсөн өдрөөр хамт олноороо баяр хүргэдэг, өвчтэй, эмнэлэгт хэвтсэн албан хаагчдаа эргэдэг, гачигдал тохиолдсон үед тусалдаг уламжлал тогтсон. Олон нийтийн ажлын оролцоог үр дүнгийн гэрээг дүгнэх нэг үзүүлэлт болгосон.

#### 4. Архив, албан хэрэг хөтлөлтийг сайжруулах чиглэлээр:

- Тайлант онд манай байгууллагад 305 албан бичиг ирснээс 146 албан бичиг Захиргаа, хуулийн хэлтэст, 75 бичиг Санхүүгийн аудитын хэлтэст, 83 бичиг Гүйцэтгэлийн аудитын хэлтэст, 1 бичиг Чанарын хяналтын хэлтэст ирсэн байна. Үүнээс хариутай албан бичиг 65 байгаагаас Захиргаа, хуулийн хэлтэст 62, Гүйцэтгэлийн аудитын хэлтэст 1, Санхүүгийн аудитын хэлтэст 2 албан бичиг ирснийг цаг тухай бүрт нь хариуг төлөвлөн зохих байгууллагад хүргүүлсэн.
- Манай байгууллагаас 199 албан бичиг бусад байгууллага, иргэнд хүргүүлсэн бөгөөд үүнээс 123 албан бичиг Захиргаа, хуулийн хэлтсээс, 36 бичиг Санхүүгийн аудитын хэлтсээс, 37 бичиг Гүйцэтгэлийн аудитын хэлтсээс, 1 бичиг Чанарын хяналтын хэлтсээс явуулсан. Хариутай албан бичиг 91 явуулснаас 27 нь Захиргаа, хуулийн хэлтсээс, 30 нь Санхүүгийн аудитын хэлтсээс, 34 нь Гүйцэтгэлийн аудитын хэлтсээс явуулсан байх бөгөөд 77 бичгийн хариу ирж, үлдсэн 14 бичгийн хариу ирүүлэх хугацаа болоогүй байна.
- Байгууллагын архивын нөхөн бүрдүүлэлтийг 2015 оны 03 дугаар сарын 09-13-ны өдрүүдэд хийж, байнга хадгалах 11, 70 жил хадгалах 4, түр хадгалах 101 баримт, нийт 116 баримт хүлээн авсан.

- Байгууллагын дэргэдэх баримт бичиг нягтлан шалгах комиссыг 2015 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/04 дугаар тушаалаар байгуулан ажлын төлөвлөгөөний дагуу ажилласан. Тус комисс 2 удаа хуралдаж “Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журам”, “Байгууллагын архивын журам”-ыг эхний хуралдаанаар, “Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ыг батлуулах асуудлыг дараагийн хуралдаанаар тус тус хэлэлцэн шийдвэрлэсэн.
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2015.05.18-ны “Архивын Улсын үзлэг явуулах төв комиссын бүрэлдэхүүн, удирдамжийг батлах тухай” 124 дугаартай захирамжийн дагуу байгууллагын даргын 2015.06.22-ны өдрийн А/06 тушаалаар “Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх комисс” байгуулагдан тус үзлэгт бэлтгэн ажилласан. Бэлтгэл ажлын хүрээнд архивын өрөөнд шаардлагатай багаж хэрэгсэл болох чийг, дулаан хэмжигч, галын хор, гал түймрээс урьдчилан сэргийлэх самбар, элс, хүрз зэргийг авч архивын өрөөг стандартын дагуу зохих хэмжээгээр тохижуулсан.
- Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/452 дугаар захирамжийн хэрэгжилтийн дагуу 2014 оны захирамжлалын 75 цаасан баримтанд цахим хувь үйлдэн, тусгай төрлийн архив үүсгэсэн. “Төрийн архивын онлайн нэгдсэн програм” <http://lavlagaa.ub.gov.mn>-д дээрх баримтуудын агуулгыг тодорхойлон шивж, цахим нөхөн бүрдүүлэлт хийсэн. Байгууллагын албан хаагчдын цахим файлаар байгууллагын архивт тусгай төрлийн архив үүсгэн, 13 CD, 2 DVD-ийг архивт хүлээн авсан.
- Нийслэлийн Засаг даргын 2015.03.06-ны өдрийн А/172 дугаар захирамжийн дагуу архивын эрхлэгч /ажилтан/-ийг хадгалалт ашиглалтын нөөц хувь үүсгэхэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж /компьютер, хэвлэгч, хувилагч, сканер, гэрэл зургийн аппарат, цаас устгагч машин/-өөр хангаж ажилласан.
- Мөн нийслэлийн Засаг даргын 2015 оны А/177 дугаар “Архивын сан хөмрөгт нөхөн бүрдүүлэлт хийх ажлын нийтлэг журам батлах тухай” захирамжид тусгасан хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулан нийслэлийн Архивын газрын дэргэдэх ББНШАЗК-ын хуралдаанаар батлуулж, мөрдөн ажилласан.
- Байгууллагын дотооддоо мөрдөх “Албан хэрэг хөтлөлтийн журам”, “Архивын дүрэм”-ийг шинээр боловсруулан байгууллагын даргаар батлуулан, нийт албан хаагчдад танилцуулан мөрдөж ажилласан.
- Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн ажлын зохион байгуулалтын улсын үзлэг 2015.10.02-ны өдөр тус албанд ирж, 4 чиглэлээр ажил шалгасан. Тус үзлэгээр манай байгууллага архивын ажлаар 83.5%, албан хэрэг хөтлөлтийн байдлаар 93.8%, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлж буй байдлаар 98.1%, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтаар 90.7%, нийт дүнгээр 91.2% буюу А үнэлгээ авсан нь агентлагуудын дунджаас 0.4%-иар, үзлэгийн нийслэлийн салбар комиссын 9 дүгээр ажлын хэсгийн шалгасан 11 агентлагийн дундажаас 1.7%-иар дээгүүр байна. Мөн тус улсын үзлэгийн Нийслэлийн салбар комисст байгууллагын дарга Д.Нацагдорж, Гүйцэтгэлийн аудитын хэлтсийн дарга Ж.Жамбалдорж, Эрүүл мэндийн салбар комисст Захиргаа, хуулийн хэлтсийн дарга Я.Сарансүх, Боловсролын салбар комисст Гүйцэтгэлийн аудитын хэлтсийн ахлах шинжээч Н.Наранчимэг нар амжилттай ажиллаж, байгууллагын дарга Д.Нацагдорж шилдэг ажилтнаар шалгарч мөнгөн шагналаар шагнуулсан.
- Байгууллагын хэмжээнд 2015.12.08-ны байдлаар 26 өргөдөл ирснээс 24 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэсэн. 1 өргөдлийг хариуцсан албан хаагч

өвчтэй байснаас өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг програмд оруулж чадалгүй хугацаа хэтрүүлсэн. 1 өргөдөл шийдвэрлэх шатандаа явж байна.

- 2015.12.07-ны байдлаар манай байгууллагын өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 20 хоног 5 цаг 14 мин байна.

5. Дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахад хэлтсүүдийн үйл ажиллагааг чиглүүлэх талаар:

- УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр Засгийн газар, сайд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосон нийт 34 тогтоол, шийдвэрийн 88 заалтыг хяналтад авч, байгууллагын жилийн төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжилтийг зохих ёсоор ханган, биелэлтийг тогтоосон хугацаанд нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. Тухайлбал Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 09 дугаар зарлиг “Үйлдвэржилтийг эрчимжүүлэх талаар Засгийн газарт чиглэл өгөх тухай”, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн “Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2015 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/105 “Улаанбаатар хотод ажил эхлэх цагийг өөрчлөх тухай”, 2015 оны А/172 “Байгууллагын архивын үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага, хадгалалтын горимыг тогтоож мөрдүүлэх тухай журам батлах тухай” захирамжийн хэрэгжилтийг хангаж ажилласан.
- Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн, Засаг даргын удирдлагын зөвлөлийн 19 удаагийн хурлаас өгсөн 26 үүрэг даалгаварыг 100% биелүүлж, биелэлтийн тайланг нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст [www.ulaanbaatar.mn](http://www.ulaanbaatar.mn) цахим хуудсаар хугацаанд нь хүргүүлсэн.

6. Байгууллагын үйл ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр:

- Байгууллагын дүрмийг шинэчлэн боловсруулж батлуулахаар хэлтсийн дарга нараас санал авч, өөрчлөлт оруулан нэгтгэж, хянаж батлуулахаар нийслэлийн Засаг даргын тамгын газрын хууль, эрх зүйн хэлтэст дүрмийн төслийг хүргүүлсэн.
- Байгууллага, албан хаагчдын хоорондын хөдөлмөрийн зарим харилцааг оновчтой зохицуулах зорилгоор хөдөлмөрийн дотоод журамд зарим өөрчлөлт оруулахаар албан хаагчдаас санал авч тусган өөрчлөлтийг батлуулав.
- “Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журам”, “Байгууллагын архивын журам”, “Цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам”-ыг шинээр боловсруулан мөрдөж байна.
- Байгууллагын даргын болон нийслэлийн зарим удирдлагын гаргаж буй тушаал, шийдвэр хууль, эрх зүйд нийцэж байгаа эсэхийг хянан зөвлөгөө өгч ажилласан. Тухайлбал нийслэлийн Засаг даргын санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан орлогч Н.Батаад 2 удаа асуудлын хариу албан бичиг, байгууллагын дарга Д.Нацагдоржийн гаргасан 13 А тушаал, 43 Б тушаалын төсөл боловсруулж батлуулсан.

- 2015 онд байгууллагын хамт олны 3 удаагийн хурал, даргын зөвлөлийн 27 удаагийн хурлыг зохион байгуулж, хурлын тэмдэглэл хөтлөн албажуулсан. Даргын зөвлөлийн хурлаас өгөгдсөн 86 үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хэлтсийн дарга нараас авч нэгтгэн удирдлагад танилцуулж ажилласан бөгөөд өгөгдсөн 86 үүргээс 85 нь 100% биелэснээр хэрэгжилт 98.84%-тай байна. Хэрэгжээгүй байгаа 1 ажил нь стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулах ажил байгууллагын даргаар хянуулах шатанд байна.
- Байгууллагын өдөр тутмын болон аудитын үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн актуудыг албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Нийслэлийн хэмжээнд мөрдөж буй хууль, эрх зүйн зарим актыг боловсронгуй болгох 9 багц санал боловсруулан Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлсэн. Монголын тээвэр, холбоо, газрын тосны ажилтны үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны нэхэмжлэлтэй, Нийслэлийн Засаг даргынхариуцагчаар оролцсон захиргааны хэрэгт хамтран хариуцагчаар оролцож, тайлбар гаргаж өгсөн.
- Байгууллагын дэргэдэх ёс зүйн хороог шинэчлэн байгуулах нууц санал хураалт явуулснаар ёс зүйн хорооны даргаар Чанарын хяналтын хэлтсийн дарга С.Буманцэцэг, гишүүдээр Захиргаа, хуулийн хэлтсийн дарга Я.Сарансүх, Гүйцэтгэлийн аудитын хэлтсийн шинжээч Н.Наранчимэг нарыг томиллоо. 2015 оны байдлаар албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөн ажилласнаар ёс зүйн зөрчлийн талаар гомдол гараагүй байна.
- Албан хэрэгцээнд шаардлагатай зарим ном товхимлын сантай болж бүртгэлжүүлэн, албан хаагчдад үйлчилсэн. Тухайлбал, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын 17 эмхтгэл, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, дотоод аудитын 14, авилгын эсрэг 3, төрийн мэдээлэл, хэрэглээний стандартын 13 нийт 83 ном, товхимол, сэтгүүлтэй болсон.
- Авлигатай тэмцэх газрын даргын тушаалаар батлагдсан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны шинэчилсэн жагсаалтын дагуу давхардсан тоогоор холбогдох 13 албан хаагчийн мэдүүлгийг авч, тайлан мэдээг зохих хугацаанд гаргаж өгсөн. Мөн шинээр албан тушаалд томилогдож буй 11 иргэн, албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг авч Авлигатай тэмцэх газраар хянуулсан. Аудитор, шинжээчдээс аудитын ажил эхлэх бүрт ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авч давхардсан тоогоор 100 орчим мэдүүлгийг Авлигатай тэмцэх газрын програмд бүртгэсэн.
- Мөн 2015 оны эхний хагас жилийн байдлаар байгууллагын даргын өмнө онд гаргасан 3 тушаалд кодификаци хийн, бүртгэл хөтлөсөн.

7. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг хууль журамд нийцүүлэн олон улсын стандартын дагуу хөтлөн явуулах чиглэлээр:

- Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт дараах өөрчлөлтүүдийг шинэчлэн оруулж мөрдөн ажиллаж байна. Үүнд:
- 1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, эрх зүйн акт болон Улсын салбарын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС)-ын дагуу шинэчлэн мөрдсөн.
- 2. Нэр данс зөрүүтэй гүйлгээг орлого, зарлагад хүлээн зөвшөөрөхгүй.
- 3. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг орлогоор хүлээн зөвшөөрөхгүй.



- 4. Засгийн газрын 233-р тогтоол хүчингүй болсонтой холбоотойгоор байгууллагын элэгдлийн тооцооллыг шинэчилсэн.
- 5. Няравын үүрэг хариуцлагыг илүү тодорхой болгосон.
- Байгууллагын орлого, зарлагын гүйлгээг холбогдох стандартын дагуу бүртгэж, сар бүр төсвийн гүйцэтгэлийн мэдээ, жижиг мөнгөн сангийн тайланг гүйцэтгэлээр, материалын тайлан болон санхүүгийн тайланг улирал бүр гаргаж, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлэн баталгаажуулж ажилласан. Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ)-ын тухай хуулийн дагуу байгууллагын нийгмийн даатгалын тайлан, хувь хүний орлогын албан татварын тайланг гаргаж онлайн програмд шивж, цаасаар хүргүүлэн баталгаажуулсан. Байгууллагаас 2015 онд нийт 22 албан хаагчийн нийгмийн даатгалын шимтгэлд 21,343.9 мянган төгрөг төлсөн.
- Байгууллагын 2016 оны төсвийн төсөл, 2017-2018 оны төсвийн таамаглалыг нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлсэн. Байгууллагын 2016 оны төсвийн төслийн саналыг 541,615.6 мянган төгрөгөөр өгсөн нь өмнөх онтой харьцуулахад 163 сая төгрөгөөр өссөн. Энэ нь орон тоо 18-аас 22 болж нэмэгдэн цалингийн зардал өссөнтэй холбоотой бөгөөд холбогдох хангамжийн бараа материалын зардал мөн дагаж өссөн. Түүнчлэн 2015 онд байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, багаж техник хэрэгслийн худалдан авах зардал, программ хангамж худалдан авах зардал, нэг удаагийн тэтгэмжийн зардал өссөн. Үүнд инфляцийн үнийн өсөлтийг тооцсон болно.
- Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл 2015 онд Нийслэлийн Өмчийн харилцааны газартай Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээг 2015 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан. Мөн цаг үеийн асуудлаар нийт 6 удаа хуралдаж хурлын тэмдэглэл хөтөлсөн байна.
- Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу байгууллагын эд хөрөнгийн хагас, бүтэн жилийн тооллогыг явуулж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, нөөцийн ашиглалтын байдал, тооллогын дүнг нэгтгэн дүгнэлт гаргасан бөгөөд тооллогоор илэрсэн зөрчил дутагдал үгүй байна. Байгууллагын үндсэн хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хянаж, хөрөнгийн хөдөлгөөнийг тухай бүр бүртгэж ажилласан. 2015 оны жилийн эцсийн байдлаар нийт 36 нэр төрлийн 80,937.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлд байна.
- Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын дагуу бараа материалын тайланг улирал бүр, жижиг мөнгөн сангийн зарцуулалтын тайланг тухай бүр гүйцэтгэлээр гарган ажилласан. Жижиг мөнгөн сангийн 950,000 төгрөгөөр байгууллагын ажлын хэрэгцээнд зориулж нийт 59 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн худалдан авсан.

#### 8. Байгууллагын ил тод нээлттэй байдлыг хангах

- Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын төсөв, санхүүгийн ил тод байдал, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор байгууллагын цахим хуудсанд шилэн дансны мэдээллийн цэс үүсгэж, байгууллагын [www.internalaudit.ub.gov.mn](http://www.internalaudit.ub.gov.mn) болон шилэн дансны нэгдсэн систем [shilendans.ub.gov.mn](http://shilendans.ub.gov.mn) сайтад 2014 оны санхүүгийн тайлан, 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, 2015 оны төсөв,

төсвийн тодотгол, 2015 оны сарын бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, 1-4 дүгээр улирлын санхүүгийн тайлан, 2016 оны төсвийн төсөл, хагас бүтэн жилийн гүйцэтгэлийн KPI, 2017-2018 оны төсвийн төсөөлөл, хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэр, таван сая төгрөгөөс дээш гүйлгээ, холбогдох бусад материалуудыг нийтлэсэн.

- Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор байгууллагын нэр, лого, эрхэм зорилго, стратегийн зорилт, бүтэц зохион байгуулалт, дагаж мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, холбоо барих хаяг, хүний нөөцийн бодлогын ил тод байдлын зэрэг 14 мэдээлэл, байгууллагын 2014 оны үйл ажиллагааны тайлан, тогтоол, шийдвэрийн 2014 оны гүйцэтгэлийн мэдээ, 2014 оны авилгын эсрэг хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээллийн ил, тод байдал, иргэдийн мэдээлэл хүлээн авах эрхийг хангаж ажиллах 2014 оны төлөвлөгөөний тайлан, 2014 оны өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дэлгэрэнгүй тайлан, 2015 оны эхний хагас жилийн KPI, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2015 оны ажлын төлөвлөгөө, тайлан, 2015 оны сургалтын төлөвлөгөө, тайлан, Авилгын эсрэг хэрэгжүүлэх ажлын 2015 оны төлөвлөгөө, тайлан, Архивын хадгаламжийн нэгжийг гамшгийн эрсдэлээс хамгаалах төлөвлөгөө, Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэхэд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, биелэлт, 2015 оны өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дэлгэрэнгүй тайлан, цаг үеийн мэдээ мэдээлэл зэрэг нийт 50 орчим мэдээг байгууллагын цахим хуудсанд нийтлэсэн.
- Хүний нөөцийн бодлогын ил тод байдлыг хангах зорилгоор төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтны ёс зүйн дүрэм, ажлын байрны тодорхойлолт, мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм, төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны зар зэрэг нийт 14 мэдээг байгууллагын цахим хуудсанд нийтлэсэн.

#### 9. Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн технологийн хэрэглээг нэмэгдүүлэх

- Интернэтийн үйлчилгээг Нийслэлийн мэдээлэл технологийн газар, Комтел ХХК-аас 2Mb-ын урсгалыг авч, интернэтийн урсгалын хурдыг <http://192.168.205.1/graphs/iface/Audit/> системээр хэмжин ажилласан.
- Дотоод сүлжээний техник хангамж болох 6 свич, сүлжээний кабел зэргийн хэвийн ажиллагааг хангаж ажиллав. Нийслэлийн Мэдээллийн технологийн газраас Нийслэлийн нэгдсэн сүлжээнд 3 удаа тохиргоо хийхтэй холбоотойгоор дотоод сүлжээний доголдол гарах бүрт нь гэмтлийг засварлав. Байгууллагын 20 компьютер, бусад техник хэрэгсэл дотоод, гадаад сүлжээнд бүрэн хэмжээгээр холбогдон ажилласан. Компьютерийн программ хангамж болон техник хангамж, принтер, факс, сканнерийн засварыг цаг тухайд нь хийж хэвийн ажиллагааг хангасан. Байгууллагын нийт 20 компьютерт албан ёсны эрхтэй хортой кодны эсрэг програм хангамж суулгаж, Галт хана (firewall) системээр сүлжээний аюулгүй байдлыг хангасан.
- Smartcity, э-оффис, цахим архив, захирамжлалын баримт бичгийн биелэлтийн L monitoring, шилэн данс зэрэг төрийн ажил үйлчилгээг цахимжуулах технологийн дэвшилтэт шинэ програмуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллав. Өргөдөл, гомдлын smartcity системийн шинэчлэлтэй холбоотойгоор

байгууллагын 18 компьютерт “Хяналтын цонх” програмыг суулгаж холбогдох тохиргоог хийсэн.

- Төрийн байгууллагын цахим архив үүсгэх ажлын хүрээнд “Төрийн архивын онлайн нэгдсэн програм” <http://lavlagaa.ub.gov.mn>-д нэвтрэх эрх, болон програмын гарын авлагыг нийслэлийн Архивын газраас авч холбогдох тохиргоог хийсэн. Тус програмд байгууллагын 2014 оны захирамжлалын 75 цаасан баримтад цахим хувь үйлдэн, агуулгыг тодорхойлон шивж, цахим нөхөн бүрдүүлэлт хийсэн.
- Захирамжлалын баримт бичгийн [monitoring.ub.gov.mn](http://monitoring.ub.gov.mn) цахим системд нийт 34 тогтоол, шийдвэрийн 88 заалтын хэрэгжилт, биелэлтийг тогтоосон хугацаанд илгээсэн.
- Албан хаагчдад албан хэрэгцээнд нь зориулж [internalaudit.ub.gov.mn](http://internalaudit.ub.gov.mn) домайн нэртэй цахим шуудангийн үйлчилгээг үзүүлж, ажилд шинээр томилогдсон 8, чөлөөлөгдсөн 5 албан хаагчдын цахим шуудангийн хаяг шинээр нээх, хаах ажлыг тухай бүрт хийж гүйцэтгэн, шинэ 8 албан хаагчдад цахим шууданг ашиглах заавар зөвлөгөө өгч, техникийн дэмжлэг өгч ажилласан.
- Албан хаагчдын компьютерийн програм хангамжийн хэвийн ажиллагааг хангаж, систем нь гэмтсэн буюу вирустсэн 4 компьютерийн програм хангамжийг шинээр суулгах ажлыг тухай бүр хийж, давхардсан тоогоор нийт 120 албан хаагчдад компьютер техник хангамжийн чиглэлээр дэмжлэг туслалцааг өдөр тутам үзүүлж ажилласан. Үүнээс ихэнх нь хэрэглээний програм хангамж, оффисийн тоног төхөөрөмжийн хэрэглээний талаар байсан.
- Байгууллагын мэдээллийн технологитой холбоотой харилцааг зохицуулах зорилгоор “Цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам”-ыг боловсруулж, байгууллагын даргын 2015 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн А/12 тушаалаар батлан, байгууллагын нийт албан хаагчдад албаны цахим шуудангаар илгээж танилцуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан.

#### **ХОЁР. 2015 ОН ХЭРЭГЖҮҮЛСЭН АУДИТЫН ТАЛААР:**

НДАА нь 2015 онд нийслэлийн Засаг даргын хамрах хүрээний нийт 42 байгууллагад гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитыг гүйцэтгэхээр төлөвлөснөөс 42 байгууллагад аудитын ажлыг гүйцэтгэж төлөвлөгөөг 100 хувь биелүүлсэн.

Аудитын төрөл	Зөвлөмжийн тоо	Төлөвлөсөн аудит	Гүйцэтгэсэн аудит
Санхүүгийн аудит	71	21	21
Гүйцэтгэлийн аудит	320	21	21
<b>Дүн</b>	<b>391</b>	<b>42</b>	<b>42</b>

Захиалгат аудитыг дараах 2 байгууллагад гүйцэтгэсэн. Үүнд:

1. ЧД-ийн Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт;
2. СБД-ийн ЭМТ-д гүйцэтгэсэн захиалгат аудит,
3. Зорчигч тээврийн нэгтгэлийн 2014 оны сүүлийн 2 сарын худалдан авах ажиллагааны аудит.

2015 онд хэрэгжүүлсэн дээрх 42 аудитын ажлын хүрээнд **391** зөвлөмж хүргүүлж, нийт **30,099.4** сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 27,165.8 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх, 2,905.3 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулах, 28.3 сая төгрөгийн зөрчлийг төсөвт буцаан төвлөрүүлэхээр холбогдох байгууллагуудад дүгнэлт, зөвлөмж өгч ажиллаа.

Аудитын төрөл	Зөрчлийн дүн	Өгсөн зөвлөмж		
		Төсөвт буцаан төвлөрүүлэх	Данс бүртгэлд тусгах, залруулах	Давтан гаргахгүй байх
Санхүүгийн аудит	17,787.2	0.0	1,281.8	16,505.4
Гүйцэтгэлийн аудит	12,312.2	28.3	1,623.5	10,660.4
<b>Дүн</b>	<b>30,099.4</b>	<b>28.3</b>	<b>2,905.3</b>	<b>27,165.8</b>

## 2.1. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЛААР:

Гүйцэтгэлийн аудитын багт хэлтсийн дарга Ж.Жамбалдорж, ахлах шинжээч Н.Наранчимэг, ахлах аудитор Б.Эрдэнэсүрэн, аудитор Ц.Дуламдорж, шинжээч Б.Мягмарзаяа, Ц.Болдбаатар, О.Баярмагнай нарын бүрэлдэхүүнтэйгээр 1500 хүн/цаг ажиллаж, тайлант хугацаанд /Шаардлагатай үед бусад хэлтсүүдтэй хамтран/ өөрийн чиг үүргийн дагуу дараах захиалгат /Сэдвийн/ аудитын ажлыг гүйцэтгээд байна. Үүнд:

### А. Захиалгат аудитын ажил:

1. Нийслэлийн Засаг даргын Санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан орлогч, нийслэлийн Дотоод аудитын хорооны гишүүн Н.Батаагийн баталсан удирдамжаар "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ-ыг байгуулагдсанаас хойшхи хугацааг хамруулан худалдан авах үйл ажиллагаанд захиалгат аудитыг 2015 оны 05 дугаар сард явуулсан.
2. Нийслэлийн Засаг дарга, Дотоод аудитын хорооны дарга Э.Бат-Үүлийн баталсан удирдамжаар Хан-Уул дүүргийн 18 дугаар сургуулийн үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд захиалгат аудит хийж дүнг нийслэлийн хэмжээнд дээрх чиглэлээр хийгдсэн шалгалтын дүнд оруулан 2015 оны 09 дүгээр сард тайлагнасан ба Удирдлагын зөвлөлийн хуралд хэлэлцэгдсэн.
3. Нийслэлийн Засаг даргын Санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан орлогч, нийслэлийн Дотоод аудитын хорооны гишүүн Н.Батаагийн баталсан удирдамжаар Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв, төвийн харьяа Сүхбаатар сувиллын цогцолборын 2014 он болон 2015 оны эхний 3 улирлын үйл ажиллагаанд захиалгат аудитыг 2015 оны 11,12 дугаар саруудад хийсэн. Аудитын урдчилсан дүнгээс үзэхэд төвийн хэмжээнд санхүүгийн ноцтой зөрчил илэрч байгаа ба Сувиллын цогцолборын үйл ажиллагаа доголдож иржээ гэсэн дүгнэлт гарч байна.
4. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн ажлын хэсэгт хэлтсийн дарга Ж.Жамбалдорж, ахлах шинжээч Н.Наранчимэг нар 2015 оны 9, 10 дугаар саруудад ажиллан 54 байгууллагад үзлэг хийн, дүнг нэгтгэн гаргаж тус тусын ажлын хэсгүүдэд өгсөн.
5. Захиалгат аудитын удирдамжийг тухай бүр боловсруулан Аудитын хорооны даргаар батлуулан аудитыг явуулж ирсэн.

6. Дээрх аудитуудад Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Улсын салбарын дотоод аудитын гарын авлага, Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ, Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын арга зүйг ашигласан болно.

#### **Б.Төлөвлөгөөт гүйцэтгэлийн аудит:**

##### **□ Гүйцэтгэлийн аудитыг нийслэлийн харьяа 16 байгууллагад**

1. Нийслэлийн Архивын газар
2. Дүүргүүдэд эрх шилжсэн ажилд хийсэн сэдвийн аудит
3. Энэрэл эмнэлэг
4. Хүүхэд залуучуудын сургалт, хүмүүжлийн тусгай цогцолбор
5. Соёлын төв өргөө
6. Амьдрах ухаан, сургалт үйлдвэрлэлийн тусгай төв
7. Улаанбаатар хотын музей
8. Нийслэлийн Биеийн тамир, спортын газар
9. Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар
10. Авто худалдааны цогцолбор ОНӨААТҮГ
11. Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ
12. Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ
13. Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ
14. Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ
15. Нийслэлийн харьяа ОНӨТҮГ-уудын эд хөрөнгийн эрхийн байдал, статус,

бүтэц,

зохион байгуулалт, санхүүжилт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийн

байдал

16. Нийслэлийн Төрийн сангийн зарцуулалт

##### **□ Сэдвийн 3 аудит**

- 1.УБ хотын ерөнхий болон ХЕТ
- 2.Найрсаг Улаанбаатар хөтөлбөр
- 3.Ухаалаг Улаанбаатар хөтөлбөр


##### **□ Захиалгат 2 аудит**

- 1.Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ/захиалгат/
- 2.СБД-ийн ЭМТ /захиалгат/

Гүйцэтгэлийн аудитыг дараах зорилтуудын хүрээнд хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Байгууллагын засаглалын үйл явцыг үнэлэн, сайжруулах зөвлөмж өгөх;
- Стратеги төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн болон контракт гэрээний хэрэгжилтэд холбогдох хууль,эрх зүйн актуудыг үндэслэн үнэлэлт дүгнэлт хийх;
- Байгууллагын даргын гаргасан тушаал шийдвэрийн хэрэгжилт, архив албан хэрэг хөтлөлт, байгуулсан гэрээ, хэлцлийн биелэлтэнд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- Дотоод хяналтын тогтолцоотой эсэх, түүнээс гаргасан шийдвэр, хэрэгжилтэнд зөвлөмж өгөх;
- Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, батлагдсан төсөв /орлого, зардал, ашиг/, төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт буюу гүйцэтгэл зэрэгт үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгөх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, хандив зээлийн хэрэгжилт, үр өгөөж болон төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдалд үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгөх.

Гүйцэтгэлийн аудитаар аудитаар нийт 12,312.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж нийт 320 зөвлөмж өгснөөс 1,623.5 сая төгрөгийн зөрчлийг тайланд залруулах, 10,660.4 сая төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, 28.3 сая төгрөгийн зөрчлийг төсөвт буцаан төвлөрүүлэх зөвлөмжийг хүргүүлсэн.



## 2. САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЛААР:

Санхүүгийн аудитын багт хэлтсийн дарга Д.Үүрийнтуяа, ахлах аудитор Д.Лувсанчимэд, С.Цолмон, аудитор Б.Уранбилэг, Ч.Гүрбазар, шинжээч Б.Отгонцэрэн, Б.Ононбайгаль, Б.Баярмаа нарын бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж, тайлант онд албаны дунд хугацааны төлөвлөгөө, аудитын жилийн төлөвлөгөөнд үндэслэн аудитын хамрах хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийж үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөмж хүргүүлэх, зөвлөмжийн хэрэгжилтийг хянах зэрэг ажлыг хийж гүйцэтгэлээ.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3. “Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна.” заалт, Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоол, Нийслэлийн Дотоод аудитын хорооны дарга Э.Бат-Үүлийн 01 тоот тогтоолоор баталсан тус албаны 2015 оны аудитын жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор нийт 20 байгууллагын 2014 он, 2015 оны II, III улирлын байдлаарх санхүүгийн тайланд санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн.

Санхүүгийн аудитыг дараах 6 зорилтын хүрээнд гүйцэтгэсэн бөгөөд аудитаар нийт 17,787.2 сая төгрөгийн зөрчил илэрч 71 зөвлөмж өгснөөс 1,281.8 сая төгрөгийн зөрчлийг тайланд залруулах, 16,505.4 сая төгрөгийн зөрчлийг цаашид дахин давтан гаргахгүй байх дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн, хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж ажиллаа. Үүнд:

- Санхүүгийн тайлагнал
- Эргэлтийн хөрөнгө

- Эргэлтийн бус хөрөнгө
- Хөрөнгийн эх үүсвэр
- Орлого
- Зардал


Аудитыг гүйцэтгэхдээ албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, биет тест хэрэгжүүлэх зэрэг нотлох баримт цуглуулан, нөхцөл байдлын шинжилгээ хийж нийт 20 байгууллагын 4 байгууллагад “**Хангалттай**”, 10 байгууллагад “**Сайжруулалт хэрэгтэй**”, 6 байгууллагад “**Их хэмжээний сайжруулалт хэрэгтэй**” дүгнэлт өгч аудитыг гүйцэтгэсэн.

### **ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД СЭДВИЙН АУДИТ ХИЙЖ ДҮГНЭЛТ ӨГЧ, ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:**

Монгол Улсын Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. “Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.”, Нийслэлийн Засаг даргын 2015 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/01 дүгээр захирамжийн 2. “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг нийслэл, дүүргийн хэмжээнд зохион байгуулахад дараах хяналт шалгалтыг тогтмол хэрэгжүүлж, ажиллахыг нийслэл, дүүргийн Дотоод аудитын албанд үүрэг болгосугай.” заалтын дагуу нийслэлийн Дотоод аудитын алба нь нийслэл болон дүүрэгт харьяалагдах төсөвт 675, ОНӨААТҮГ 44, нийт 719 байгууллагын мэдээллийг сар бүр нэгтгэн ажилласан. Үүнд:

#### **Төсөвт байгууллагын хувьд:**

Нийслэл болон дүүргийн Дотоод аудитын албад нь Шилэн дансны тухай хууль болон журмын хэрэгжилтэнд сар бүр тогтмол хяналт тавьж ажилласны үр дүнд Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 4.1.2. “тухайн жилийн төсөв, орлого, урсгал зардал, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF, Excel, XML форматаар;” 4.1.6. “төсвийн хагас жилийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулан, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт 8 дугаар сарын 15-ны дотор, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор, сар, улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF, Excel, XML форматаар;” заалтуудын дагуу төсөвт байгууллагууд 2015 оны I сард батлагдсан төлөвлөгөөг 77.7 хувь, гүйцэтгэлийн мэдээг 73.1 хувь оруулж байсан бол XI сард 100 хувийн гүйцэтгэлтэй байна.



**Нийслэл, дүүргийн харьяа ОНӨААТҮГ-ын хувьд:**

Нийслэл болон дүүргийн ОНӨААТҮГ 44 байгууллагийн улирал бүр мэдээлдэг “Эрх бүхий байгууллагаас баталсан төсөв гүйцэтгэлийн KPI”-ийн мэдээлсэн байдал 2015 оны I дүгээр улиралд 65.9 хувь байсан бол хяналт тавьж ажилласны үр дүнд III дугаар улирлын байдлаар 100 хувь болж өссөн.

Нийслэл болон дүүргүүдийн Дотоод аудитын албад нь 2015 оны II сараас эхлэн дээрхи 719 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд сар бүр хяналт тавин ажилласан бөгөөд хэрэгжилтийг эхний 3 сарын тайланг Нийслэлийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2015 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн хуралд, Нийслэлийн Дотоод аудитын хорооны 2015 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн хуралд тус тус танилцуулсан. Мөн тус хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараах ажлуудыг хийлээ. Үүнд:

- 2015 оны 6 дугаар сарын 18-ны өдөр Санхүү төрийн сангийн хэлтсээс зохион байгуулсан хамрах хүрээний байгууллагуудын нягтлан бодогч нарын семинарт Шилэн дансны хуулийн хэрэгжилт болон, хагас жилийн үзлэг тооллоготой холбоотой presentation танилцуулсан;
- Нийслэлийн Засаг даргын 2015 оны 01 дүгээр сарын 08-ны А/01 дүгээр захирамжаар байгуулсан “Нийслэлийн шилэн нэгдсэн мэдээллийн системийг хөгжүүлэх, шилэн дансны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах” ажлын хэсэгт тус хэлтсийн дарга Д.Үүрийнтуяа, шинжээч Ц.Болдбаатар нар орж ажлын хэсгийн 6 удаагийн хуралд суун шилэн дансны програм хангамжийг хийхэд саналаа бичгээр болон бусад хэлбэрээр өгсөн;
- Сангийн яаманд Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтийн нийслэл, дүүргүүдийн I, II улирлын мэдээлэл, мөн тус яамны "Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд чиглэл хүргүүлэх тухай" 2015.10.05-ны өдрийн 13-1/5881 тоот албан бичгийн дагуу III улирлын мэдээллийг нэгтгэн цахим хаягаар тус тус хүргүүлсэн.



## **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн үзлэг шалгалт /2015 оны эхний хагас жил/**

НДАА нь Нийслэлийн Засаг даргын 2015 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/01 дүгээр захирамжийн 2. “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг нийслэл, дүүргийн хэмжээнд зохион байгуулахад дараах хяналт шалгалтыг тогтмол хэрэгжүүлж, ажиллахыг нийслэл, дүүргийн Дотоод аудитын албанд үүрэг болгосугай.” заалтын дагуу нийслэлд харьяалагдах 89 байгууллага /төсөвт-69, ОНӨААТҮГ-20/-д үзлэг шалгалтыг явуулсан.

2015 оны эхний хагас жилийн үзлэг шалгалтыг хийхдээ 6 дугаар сард нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад Засаг даргын удирдамжийг танилцуулан дараах баримт материалыг татан авч шилэн дансны нэгдсэн сайт [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn), болон нийслэлийн [www.shilendans.ub.gov.mn](http://www.shilendans.ub.gov.mn) цахим хуудсанд байршуулсан мэдээлэлтэй тулган үзлэг шалгалтыг гүйцэтгэсэн. Үүнд:

1. Дансны хуулга
2. Мөнгөн хөрөнгийн журнал
3. 2015 оны төсвийн хуваарь
4. Төсвийн гүйцэтгэлийн мэдээ
5. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
6. Санхүүгийн тайлан

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн нэгдсэн үзлэг шалгалтаар нийт 76,058.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж, тухай бүр залруулан ажилласан. Үүнд:

- Жилийн төсөв, гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт-гүйцэтгэлийн KPI-г мэдээлээгүй 242 төсөвт байгууллага;
- Төсвийн гүйцэтгэлийн 6 дугаар сарын мэдээг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй 10 төсөвт байгууллага;
- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй 131 байгууллагын 72,639.3 сая төгрөгийн гүйлгээ ;
- Тендер шалгаруулсан боловч Шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй 1 байгууллага;
- Байгууллагын өмч хөрөнгөтэй холбоотой шийдвэрийг цахим хуудсанд байршуулаагүй 73 байгууллагын 3419.7 сая төгрөг;
- Эхний хагас жилийн санхүүгийн тайлан шивээгүй 165 төсөвт байгууллага;
- Эрх бүхий байгууллагаас баталсан жилийн төсөв, гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт-гүйцэтгэлийн KPI-г мэдээлээгүй 8 ОНӨААТҮГ

Мэдээлэл дутуу оруулсан байгууллагын хариуцсан албан тушаалтантай тухай бүр холбогдон нөхөн оруулуулж дээрх алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байхыг анхааруулж зөрчлийг арилгуулан ажиллаа.

Мөн 2015 оны эхний хагас жилийн үзлэгийн дүнг нийслэлийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн 8 дугаар сарын 27-ны өдрийн хуралд танилцуулан тус хурлын тэмдэглэлийг үндэслэн НЗД-ын захирамжаар 18 байгууллагын удирдлагад сануулах сахилгын арга хэмжээ авсан.

### **3. ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ТАЛААР:**

Чанарын хяналтын баг нь хэлтсийн дарга С.Буманцэцэг, Д.Нансалмаа, аудитор П.Батбилэг нарын бүрэлдэхүүнтэйгээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

1. Нийслэлийн ТЕЗ-ын багц хүрээний байгууллагуудын үйл ажиллагаа, санхүүгийн тайланд хийсэн гүйцэтгэлийн болон санхүүгийн төлөвлөгөөт аудит, сэдвийн аудит, дүүргүүдийн дотоод аудитын албаны аудитын тайланд чанарын хяналт хийсэн. Нэгдсэн тайлан гаргаж зөвлөмж боловсруулах зорилтын хүрээнд хийгдсэн ажлууд:
  - Гүйцэтгэлийн аудит, санхүүгийн аудитын тайланд чанарын хяналт хийхтэй холбоотойгоор Ажлын баримт 4001-4005-ыг боловсруулж, хэрэглэх горимыг албаны даргаар батлуулан бүх аудиторуудад танилцуулсан. 2015 оны төлөвлөгөөт аудитын тайлангуудад эдгээр чанарын хяналтын баримт дагалдан бөглөгдөж байна. Амьдрах ухаан сургалт, үйлдвэрлэлийн тусгай төв, Улаанбаатар хотын музей, Эдийн засгийн хөгжлийн газар, Уламжлалт Анагаах Ухааны Элэг Судлалын Клиник Төв зэрэг 4 байгууллагад гүйцэтгэлийн аудит хийсэн.
  - Налайх, Багануур дүүргүүдийн дотоод аудитын албаны аудитын үйл ажиллагаанд хийх чанарын хяналтын удирдамжийг батлуулж, хуваарийн дагуу 2015 оны 10 дугаар сард чанарын хяналт хийсэн.
  - 2014 онд хийгдсэн аудитын зөвлөмжийг хянах ажлын хүрээнд аудитор, шинжээчдийн зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг нэгтгэсэн. Эдгээр зөвлөмжийн хэрэгжилтийг албаны дотоод дүрмэнд заасны дагуу улирал тутам хянаж, тайланг нэгтгэсэн.
  - Нийслэлийн ТЕЗ-ын хамрах хүрээний байгууллагууд аудитын багт хамрагдаж ажилласан. /СБД, БНД, БЗД-үүдийн Халамжийн хэлтэс, СБД-ийн Эрүүл мэндийн төв/
  - 2014 оны зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг нэгтгэж 2015 оны 12 дугаар сарын 25-нд эцсийн байдлаар бэлэн болно. 2015 оны зөвлөмжийн хэрэгжилтийн файл үүсгэж байна.
2. Албаны дотоод хяналтын систем, эрсдлийн удирдлагын тогтолцоог үр өгөөжтэй үр нөлөөтэй ажиллуулах, боловсронгуй болгох талаар зөвлөмж өгч, хэрэгжилтийг ханган ажиллах зорилтын хүрээнд хийгдсэн ажлууд:
  - ✓ Нийслэлийн ТЕЗ-ын багц хүрээний байгууллагуудын эрсдэлийн шалгуур үзүүлэлтүүд, эрсдэлийн хэмжилтийн үзүүлэлтүүдийг шинэчлэх санал боловсруулж албаны даргад танилцуулсан.
3. Хамрах хүрээний байгууллагуудын дотоод аудиторуудад сургалт, семинар зохион байгуулах зорилтын хүрээнд хийгдсэн ажил:
  - ✓ 5 дугаар сарын 29-ний өдөр нийслэлийн ТЕЗ-ийн хамрах хүрээний 21 байгууллагын 4 дотоод аудитор, 18 дотоод хяналтын мэргэжилтнүүдэд “Дотоод аудит, дотоод хяналтын тухай” сэдэвт сургалт явуулсан. Тус сургалтаар дотоод аудит, дотоод хяналтын тухай ойлголтыг өгч, дотоод аудитаар илэрч буй нийтлэг зөрчил, цаашид анхаарах асуудлын талаар ярилцсан болно.
4. Нийслэлийн дотоод аудитын албаны нийт аудитор, шинжээчдийн мэдлэг, мэргэжлийн ур чадварын түвшинг тогтоох, сургалт семинар зохион байгуулах зорилтын хүрээнд хийгдсэн ажлууд:

- ✓ Албаны аудитор, шинжээчдээс түвшин тогтоох шалгалтыг УСНББОУС, СТОУС, Төсвийн тухай хууль, Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ, Дотоод аудитын тухай ойлголт, Төрийн албан хэрэг хөтлөлт, ТБОНӨХБАҮХАТ хууль, тендерийн баримт бичиг зэрэг сэдвийн хүрээнд боловсруулан авсан. Шалгалтын үр дүнгээр 2014 онд авсан Дотоод аудитын тухай, Худалдан авах ажиллагаа болон Архив бичиг хэрэг хөтлөлтийн сургалтын сэдвүүд дээр аудитор, шинжээчид дунджаас дээгүүр үнэлгээ авсан учир сургалтын өгөөж сайн байсан гэж дүгнэсэн. Мөн УСНББОУС болон СТОУС-ын талаар сургалт авбал зохистой гэж үзэж Захиргаа хуулийн хэлтэст саналаа хүргүүлсэн.
- ✓ Аудитор, шинжээчдийн нийтлэг гаргаж буй алдаа дутагдлыг судлах, түүнийг засч залруулах зорилгоор хэлтсийн дарга нар болон албаны даргаас авах санал асуулгын маягтын загварыг гарган 2015 оны төлөвлөгөөт аудитын тайлан бүр дээр тус асуулгыг авахаар төлөвлөсөн.
- ✓ 2015 оны 11 дүгээр сард Сангийн яамтай хамтран “Дотоод аудитын ажлын баримтыг хэрхэн сайн хөтлөх вэ” сургалт семинарыг зохион байгуулж оролцсон.

Хянасан: Нийслэлийн Дотоод аудитын албаны дарга

Д.Нацагдорж

Тайлан нэгтгэсэн: Захиргаа, хуулийн хэлтсийн дарга

Я.Сарансүх

2016 оны 01 дүгээр сарын 07